

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Гар бичмэлийн эрхтэй®

Батчулууны Мөнхбаяр

**Чихрийн шижин өвчний эмчилгээний үндсэн
эмийн хүртээмж, олголт, үнэнд хийсэн
судалгаа**

Е 720154 – Эм зүй

Эм зүйн ухааны магистрын зэрэг горилсон бүтээлийн хураангуй

УЛААНБААТАР ХОТ

2008 он

Магистрын судалгааны ажлыг ЭМШУИС (Захирал, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор Ц.Лхагвасүрэн), Эм зүйн сургууль (Захирал, Эм зүйн ухааны доктор, профессор С.Цэцэгмаа), Эм зүйн албаны зохион байгуулалт, эмийн технологийн тэнхим (Эрхлэгч, Эм зүйн ухааны доктор Ц.Даваасүрэн)-д хийж гүйцэтгэв.

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

Р.Цэрэнлхагва

Эм зүйн ухааны доктор, дэд профессор

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

О.Уранчимэг

Эм зүйн ухааны доктор

Магистрын зэрэг хамгаалуулах Эрдмийн зөвлөлийн хурал 2008 оны сарын өдрийн цагт ЭМШУИС-ийн Эрдмийн зөвлөлийн өргөөнд болно.

Эрдмийн Зөвлөлийн эрдэмтэн

нарийн бичгийн дарга доктор, дэд профессор/ О.Чимэдсүрэн /

Гарчиг

Удиртгал	1
Судалгааны ажлын үндэслэл	1
Судалгааны ажлын зорилго, зорилтууд	3
Судалгааны ажлын шинэлэг тал	3
Судалгааны ажлын шинжлэх ухааны ба практикийн ач холбогдол	5
Нэгдүгээр бүлэг. Хэвлэлийн тойм	6
1.1. Чихрийн шижин өвчин, түүний тархалт	6
1.2. Чихрийн шижин өвчин улс орны эдийн засагт нөлөөлөх нь	9
1.3. Чихрийн шижин өвчний эмнэл зүй, эмийн эмчилгээний товчоос	10
Чихрийн шижин өвчний эмчилгээний үндсэн зарчим	11
1-р хэлбэрийн ЧШӨ-ний эмчилгээ	12
2-р хэлбэрийн ЧШ-гийн эмчилгээ	13
1.4. Төрөөс төлбөрийг нь хариуцах тусламж үйлчилгээ	16
Төр хариуцах тусламж, үйлчилгээ үзүүлэх журам	16
Нэг. Эмнэлгийн тусламж үйлчилгээ	17
Хоёр. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ	18
Гурав. Төлбөрийг нь төр хариуцан амбулатори, поликлиникээр эм олгох өвчин, эмгэг	19
Төлбөрийг нь төр хариуцах эмийг олгох журам	19
Нэг. Нийтлэг зүйл	20
Хоёр. Төлбөрийг нь төр хариуцан амбулатори, поликлиникээр эмчлэх өвчин, эмгэг ба түүнд хэрэглэх эмийн жагсаалт	21
Хоёрдугаар бүлэг. Судалгааны объект, материал арга зүй	24
Гуравдугаар бүлэг. Судалгааны үр дүн ба хэлцэмж	26
3.1. Төлбөрийг нь төр хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмийн олголт ба эм, хөрөнгийн хүртээмжийн байдлыг улс, аймгийн түвшинд судалсан дүн	26
3.2. Төлбөрийг нь төр хариуцаж, амбулатори, поликлиникээр төлбөргүй тусламж үйлчилгээнд хамруулах Чихрийн шижингийн өвчлөлийн тархалтыг улс, аймгийн түвшинд судалсан дүн	30
3.3. Чихрийн шижин өвчний эмчилгээний үндсэн эмийн хэрэглээг судалж, эмчилгээний стандартад заасан эмийн эмчилгээтэй харьцуулан дүгнэлт хийх	35

3.4. Чихрийн шижингийн өвчлөл, эмчилгээний үндсэн эмийн бодит хэрэглээ, эмчилгээний стандартад заасан эмийн эмчилгээнд тулгуурлан эмийн хэрэгцээг тодорхойлж, стандарт эмчилгээний дундаж тунтай харьцуулсан судалгааны дүн.....	44
3.5 Төрөөс төлбөрийг нь хариуцаж иргэдэд төлбөргүй тусламж үйлчилгээний хүрээнд үнэгүй олгодог эмийн үнийг олон улсын жишиг үнэтэй харьцуулсан дүн.....	49
Дүгнэлт	52
Санал, зөвлөмж	53
Товчилсон үгийн жагсаалт.....	54
Ном зүй	55

Удиртгал

Судалгааны ажлын үндэслэл:

1992 онд батлагдсан Монгол улсын Үндсэн хуулийн 2-р бүлгийн 16-р зүйлийн 2-т зааснаар “Монгол улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” бөгөөд 16-р зүйлийн 6-д зааснаар “Монгол улсын иргэн нь эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй”, “Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно” гэж заасан билээ.

Үндсэн хуулийн эдгээр заалтын дагуу Монгол улсын иргэдэд эрүүл мэндийн тусламж үзүүлэх ажлыг “Эрүүл мэндийн тухай” хуулийн хүрээнд явуулах ёстой.

Монгол улсын Эрүүл мэндийн тухай (1998.05.07) хуулийн 4-р зүйлийн 4.1-д төрөөс иргэдэд эрүүл мэндийн зарим төрлийн тусламж, үйлчилгээг төлбөргүй үзүүлэхээр заасны дагуу “Төр хариуцах тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлан мөрдөж байгаа бөгөөд энэхүү журамд заасан сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн эмгэг, удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах эмгэгийн болон хөнгөвчлөх эмчилгээний зарим эмийн төлбөрийг төр хариуцаж, амбулатори, поликлиникээр иргэнд уг эмүүд үнэ төлбөргүй олгогдож байна.

Дээрх хууль, эрх зүйн баримт бичигт заагдсан тодорхой нэрийн өвчин, эмгэгтэй иргэний үндсэн эмчилгээнд шаардлагатай, төрөөс төлбөрийг нь хариуцан үнэ төлбөргүй олгох ёстой эмийн олголт, хүртээмжийн байдлыг Чихрийн шижин өвчний жишээн дээр судлан үнэлгээ дүгнэлт хийж, цаашид анхаарах асуудлуудыг гарган хэрэгжүүлэх шаардлага нь энэхүү судалгааны ажлыг явуулах үндэслэл болж өглөө.

ДЭМБ-ийн мэдээлж байгаагаар дэлхийн хүн амын дунд чихрийн шижин өвчний тархалт жил дутам нэмэгдэж, өнөөгийн байдлаар уг өвчнөөр өвчилсөн хүний тоо 180 саяд хүрээд байгаа ба энэхүү өвчний тархалт цаашид үргэлжилбэл 2025 он гэхэд 380 сая хүртэл өсөх хандлагатай байна гэсэн тооцоог гаргажээ.

Монгол улсын хүн амын өвчлөлийн дотор сүүлийн жилүүдэд чихрийн шижин өвчний (ЧШӨ) тархалт жил дутам нэмэгдэж, цаашид өсөх хандлагатай байгааг хүн амын өвчлөлийн жил дутмын статистик харуулж байгаа юм.

Чихрийн шижин өвчин зөвхөн насанд хүргэгчдэд үүсдэг боловч сүүлийн үед хүүхэд өвдөх нь элбэгшиж, энэ өвчинд нярайгаас авахуулаад өсвөр насны бүх хүүхдүүд өртөж одоогоор хүүхдийн чихрийн шижин өвчин маш хожуу, өөрөөр хэлбэл цусны сахар архаг байдлаар ихсэж эрхтэн системийн хүндрэл үүсгэсэн хойноо оношлогдож байна.

Чихрийн шижин өвчний тархалтын байдал, түүний эмчилгээнд хэрэглэгдэж буй эмэнд зарцуулах хөрөнгийн хэмжээ шууд шүтэлцээтэй өсч байгаа нь энэхүү өвчний эмчилгээний эмийн хэрэглээ, хангамжийн байдлыг судлан дүгнэлт гаргаж, цаашдын төлвийг тодорхойлох нь уг өвчнийг сонгон авах шалтгаан боллоо.

Судалгааны ажлын зорилго, зорилтууд:

Төлбөрийг нь төр хариуцах эмийн олголт улс, аймгийн түвшинд хэрхэн хэрэгжиж, эмийн хэрэглээ, хангамж, нийлүүлэлт, олгож буй эмийн үнэ олон улсын жишиг үнэтэй харьцуулахад ямар түвшинд байгааг Чихрийн шижин өвчний жишээн дээр судлан тогтоож, цаашид анхаарах асуудлын талаар санал дэвшүүлэхэд судалгааны ажлын үндсэн зорилго чиглэгдэв.

Дэвшүүлсэн энэхүү зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг тавьж судалгаа явууллаа. Үүнд:

1. Төлбөрийг нь төр хариуцах эмнэлгийн тусламж үйлчилгээ, эмийн олголт, хөрөнгийн хүртээмжийн байдлыг улс, аймгийн түвшинд судалгаа хийж, дүгнэлт гаргах.
2. Төлбөрийг нь төр хариуцан амбулатори, поликлиникээр эмчлэгдсэн Чихрийн шижингээр өвчилсөн өвчтөний тоог улс, аймгийн түвшингээр судлан гаргах.
3. Чихрийн шижин өвчний эмчилгээний үндсэн эмийн хэрэглээг судалж, эмчилгээний стандартад заасан эмийн эмчилгээтэй харьцуулан дүгнэлт хийх.
4. Чихрийн шижингийн өвчлөлийн үзүүлэлт, эмчилгээний үндсэн эмийн хэрэглээ, эмчилгээний стандартад (Монгол улсын хүн амын дунд зонхилон тохиолдох өвчин, эмгэгийн оношлогоо, эмчилгээний удирдамж. 2005 он) тулгуурлан эмийн хэрэгцээг тодорхойлох, ЧШӨ-ний эмчилгээний үндсэн эмийн зохистой хэрэглээг бүрдүүлэх, эмийн хангалт нийлүүлэлтийг цаашид оновчтой болгох арга замын талаар санал дэвшүүлэх.
5. Төлбөрийг нь төр хариуцдаг өвчний эмчилгээний үндсэн эмийн үнийг олон улсын жишиг үнэтэй харьцуулан дүгнэлт хийх.

Судалгааны ажлын шинэлэг тал:

Хүн амын дунд зонхилон тохиолдох чихрийн шижин өвчний өвчлөлийг тархвар судлалын судалгааны орчин үеийн аргуудыг ашиглан судлаж, уг өвчний хөдлөл зүйг гаргасны үндсэн дээр ЧШӨ-ний эмчилгээний үндсэн эмийн бодит хэрэглээнд тулгуурлан эрэлт хэрэгцээг эмийн маркетингийн аргуудаар судлан, шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлж, Монгол улсын иргэдэд хууль тогтоомжинд заасан эмнэлгийн төлбөргүй тусламж үйлчилгээ хэрхэн явагдаж байгаа байдалд үнэлгээ дүгнэлт хийсний үндсэн дээр эмийн хүртээмж, олголтыг цаашид хэрхэн сайжруулах, эрх зүйн актуудыг амьдралд хэрэгжүүлэх, эмийн зохистой хэрэглээг бүрдүүлэх чиг хандлагыг хэрэглээ,

эрэлт хэрэгцээ, импорттой холбон гаргаж тавьсанд оршино.

Судалгааны ажлын шинжлэх ухааны ба практикийн ач холбогдол:

Чихрийн шижин өвчний эмчилгээний үндсэн эмийн эрэлт хэрэгцээг орчин үед дэлхий нийтийн эм хангамжийн практикт өргөн хэрэглэж буй аргаар бодитойгоор тодорхойлсоны үндсэн дээр эмийн хангамж нийлүүлэлтийг оновчтой явуулах, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, төсөв хөрөнгийг үр ашигтай хуваарилан зарцуулах, стандарт эмчилгээг мөрдөх зэрэг практик ач холбогдол бүхий санаануудыг гаргаж тавьсан ба энэхүү судалгааг Монгол улсын хүн амын дунд зонхилон тохиолдох бусад өвчний эмийн хэрэгцээг тооцоход жишиг болгон ашиглах боломжтой юм.

Ном зүй

Үндэсний хэл дээр ашигласан ном зүй:

1. П.Батхуяг. Клиникийн эм судлалын үндэс УБ.: 2000
2. Л.Буджав. Анагаах ухааны статистикийн судалгааны арга зүй ба арга УБ.: 2000
3. Монгол Улсын Үндсэн хууль. УБ.:1998
4. Монгол улсын Эмийн тухай хууль УБ.: 2002
5. Монгол Улсын Их Хурлын 68-р тогтоол, “Эмийн талаар төрөөс баримтлах бодлого”, УБ.: 2002 он
6. Монгол улсад зонхилон тохиолдох өвчин эмгэгийн оношлогоо эмчилгээний удирдамж. ЭМЯ, ДЭМБ. УБ.: 2005
7. Монгол улсын эрүүл мэндийн статистикийн тайлан. ЭМЯ. УБ.:2000-2004
8. Монгол улсын хууль, “Төрийн мэдээлэл эмхэтгэл”.УБ.: 1994
9. М.Баярмагнай. Зонхилон тохиолдох өвчнүүдийн оношлогоо, эмчилгээнУБ.: 2005. х 165-166.
10. Ц.Мухар. Нийгмийн эрүүл мэнд. УБ.: 1999
11. Л.Мягмар, П.Батхуяг. Монгол улсын үндэсний ЗШЭ-ийн лавлах. УБ.: 2001
12. Монгол улсын эмийн бүртгэлийн жагсаалт. Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбоо. УБ.: 2006
13. С.Мөнхбат. “ЭНЭШТ-д уушгины үрэвслийн өвчнөөр стационарт эмчлэгдсэн өвчтөнүүдийн эмийн хэрэглээний судалгаа” эм зүйн ухааны магистрын зэрэг горилж бичсэн тезис.УБ.:2003.
14. Мальт улсын Нийгмийн хамгааллын яамнаас үнэ төлбөргүй олгодог эмийн мэдээлэл. 2007. <http://www.dohc.ie/>
15. Б. Оргил. Өрхийн анагаах ухаан. УБ.: 2007. х 832-849.
16. А. Өлзийхутаг. Дотор эрхтний эмгэг судлалын сурах бичиг. УБ.: 2005. х.394, 396, 399, хх. 401-403, 406-409.
17. Өвчний олон улсын ангилал. 10-р хэвлэл. 1-р боть. ДЭМБ. УБ.:1996
18. Ж.Сувд, Б.Гэрэл, Х.Отгоолой. Монгол дахь чихрийн шижин өвчний тархалт” төсөлт ажлын тайлан. УБ.: 1998
19. Л.Түвшинзаяа. “Чихрийн шижин өвчний хүндрэлийн асуудал”. УБ.: 1997
20. Р.Цэрэнлхагва. Эмийн маркетинг. УБ.: 2005. х. 185-218.
21. Цэрэнлхагва Р. Эм зүйн албаны зохион байгуулалт. УБ.: 2005.
22. Р.Цэрэнлхагва, Р.Мөнхцэцэг. Эмийн эдийн засгийн шинжилгээ. УБ.: 2006
23. Р.Цэрэнлхагва.”Уушгины цочмог үрэвслийн стационарын эмчилгээний үндсэн эмийн хэрэглээний маркетингийн судалгаа” эм зүйн ухааны докторын зэрэг

горилж бичсэн нэг сэдэвт зохиол. УБ.:2002.

24. Цэрэнлхагва Р, Эрдэнэбаяр Ц, Туяасайхан Ц. Эмийн маркетинг. УБ.: Эрхэс хэвлэлийн газар. 2005.
25. Чихрийн шижин өвчний эмнэл зүйн удирдамж . УБ.: 2004
26. ЭМЯ, ЭМХҮТ-ийн статистик мэдээлэл, - УБ.:2000
27. ЭМЯ, ЭМХҮТ-ийн статистик мэдээлэл, - УБ.:2001
28. ЭМЯ, ЭМХҮТ-ийн статистик мэдээлэл, - УБ.:2002
29. ЭМЯ, ЭМХҮТ-ийн статистик мэдээлэл, - УБ.:2003
30. ЭМЯ, ЭМХҮТ-ийн статистик мэдээлэл, - УБ.:2004
31. ЭМЯ, ЭМХҮТ-ийн статистик мэдээлэл, - УБ.:2005
32. ЭМЯ, ЭМХҮТ-ийн статистик мэдээлэл, - УБ.:2006
33. Эрүүл мэндийн увдис. УБ.:2005 №06
34. Эрүүл мэндийн төсвийн тайлан. ЭМЯ. УБ.: 1999-2004, <http://www.moh.mn>
35. Эрүүл мэндийн сайдын 2006 оны 393 тоот тушаалын хоёрдугаар хавсралт. “Төр хариуцах тусламж үйлчилгээний жагсаалт” УБ.: 2006
36. Эрүүл мэндийн хууль. УБ.: 2002
37. Эм зүйн талаар мөрдөх хууль, эрх зүйн цомог. УБ.: 2003
38. Эмийн үнийн олон улсын шалгуур удирдамж. УБ.:2003
39. Эм зүйн тусламж, үйлчилгээний эрх зүйн лавлах. ЭМЯ, ДЭМБ. УБ.: 2007

Орос хэл дээр ашигласан ном зүй

40. Дрёмова Н.Б, Соломка С.В, Дзюба В.Ф, Холявина М.М. Маркетинговые исследования потребителей медицинских и фармацевтических товаров и услуг. Новая аптека. 2001. №4. с 31-34
41. Дрёмова Н.Б, Лазарева Е.В, Соломка С. В, и др. Маркетинговые исследования лекарственного обеспечения определенных категорий больных. Современные проблемы фармацевтической науки и практики. Науч. тр. НИИФ. М: 1999. с 36-39
42. Е.А.Васюкова. “Актуальные проблемы эндокринология” 1972.
43. А.С.Ефилов, Я.Я.Германюк, С.Г.Генес “Сахарный диабет” 1983.
44. Кобзарь Л.В, Дрёмова Н.В, Чежик В.В, Мнушко З.Н, Кудайкулова А.А, Хименко С.В. Проблема изучения потребности в лекарственных средствах на современном этапе. Харьков: 1991. с 80-82
45. Кобзарь Л.В, Дрёмова Н.В, Чежик В.В. Методики краткосрочного статического прогнозирования потребности в медикаментах. Совершенствование организационных форм лекарственного обслуживания и населения. М:1978. с 169-174

46. Котлер Д. Основы маркетинга.-М.: Прогресс. 1991. с 677
47. Мнушко З.Н. Система маркетинговых исследований в фармации.
Актуальные проблемы фармацевтического маркетинга.- Харьков.: 1999.
48. Машковский М.Д. Лекарственные средства. Москва.:2000. 14 вып. С 220-272.
49. Приказ Министерства здравоохранения развития Российской Федерации от
2 декабря 2004 г. №296 г. Москва "Об утверждении перечня лекарственных средств.
<http://www.kp.ru/>
50. "Российская газета" Неделя №4189 от 6 октября 2006 г. <http://www.rg.ru/>
51. Н.Т.Старкова. "Клиническая эндокринология" 1991.

Англи хэл дээр ашигласан ном зүй

52. American Association of Diabetes Educators. 2007 www.aadenet.org
53. Centers for Disease Control and Prevention. 2007
www.cdc.gov/health/diabetes.htm
54. Carol Beaver, Review of Expenditure and Finance of Medicines in Mongolia
2006, pp.20-32
55. International drug price indicator guide 2006 pp.30-37.
56. Managing drug supply. Pharmaceutical Marketing. USA. Kumarian press. 1997.
57. Krans.H.M.J, Porta. M, Keen.H "Diabetes care and reserchin Europe" 1992.
58. Pirart.J. Diabetes mellitus and it's degenerative complications.1978.
59. Prevalenceof diabetes worldwide, World Health Organization. 2007
<http://www.int/diabetes/facts/en/>
60. WHO medicines strategy: Framework for action in essential drugs and medicines
policy 2000-2003.